

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭХ, ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ, ЭХЭД ТЭТГЭМЖ ОЛГОХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь жирэмсэн эх, 0-3 хүртэлх насын хүүхдээ асарч байгаа эх, 4 хүртэлх насын ихэр хүүхэдтэй эх /эцэг/, 3 болон түүнээс дээш хүүхэд төрүүлэн өсгөж байгаа өрх толгойлсон эх /эцэг/-д тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль тогтоомж

2.1. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Нийгмийн халамжийн тухай хууль², Гэр бүлийн тухай хууль³, Хөдөлмөрийн тухай хууль⁴, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль⁵, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж Гэр бүлийн тухай хуулийн 67.1.1-д заасны дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон иргэнийг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

² Нийгмийн халамжийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн

³ Гэр бүлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн

⁴ Хөдөлмөрийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн

⁵ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2011 оны 40 дүгээрт нийтлэгдсэн

3.1.2.“хүүхэд үрчлэн авах” гэж Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд үрчлэн авахыг;

3.1.3.“хүүхдээ асарч байгаа” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасан хүүхэд асрах чөлөөтэй байгаа болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан ажилгүй эх 0-3 насны хүүхдээ асарч байгааг;

3.1.4.“өрх толгойлсон эх /эцэг/” гэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8-д заасан иргэнийг.

4 дүгээр зүйл.Хуулийн хамрах хүрээ

4.1.Энэ хуульд заасан нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамрагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТЭТГЭМЖИЙН ТӨРӨЛ

5 дугаар зүйл.Тэтгэмжийн төрөл

5.1.Төрөөс олгох тэтгэмж нь дараах төрөлтэй байна:

5.1.1.жирэмсэн эхийн тэтгэмж;

5.1.2.0-3 насны хүүхэд асарсаны тэтгэмж;

5.1.3.ихэр хүүхдийн тэтгэмж;

5.1.4.гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-ийн тэтгэмж.

6 дугаар зүйл.Тэтгэмж авах эрх

6.1.Жирэмсний 5 сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд эх сар бүр тэтгэмж авах эрхтэй.

6.2.Төрүүлсэн, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх сар бүр хүүхэд асарсаны тэтгэмж авах эрхтэй.

6.3.Дөрөв хүртэлх насны ихэр хүүхэд төрүүлсэн эх нэг удаа тэтгэмж авах эрхтэй.

6.4.0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/ улирал бүр тэтгэмж авах эрхтэй бөгөөд хүүхдийн тоонд төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдийг хамааруулна.

7 дугаар зүйл.Тэтгэмж олгохтой холбогдсон харилцаа

7.1.Энэ хуулийн 5.1.1-5.1.3-т заасан тэтгэмжийн хэмжээг Засгийн газар батална.

7.2.Энэ хуулийн 5.1.4-т заасан тэтгэмжийн хэмжээ тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байна.

7.3.Энэ хуулийн 5.1-д заасан тэтгэмж олгох журмыг Засгийн газар батлах бөгөөд уг тэтгэмжид зарцуулах хөрөнгийг улсын төсвөөс зарцуулна.

7.4.Энэ хуулийн 5.1.2-5.1.4-т заасан тэтгэмж авах эх нас барсан, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн тохиолдолд тэтгэмжийг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үрчлэн авсан эх /эцэг/-т олгоно.

7.5.Энэ хуулийн 5.1.2-т заасан тэтгэмж авах эцэг, асран хамгаалагч хөдөлмөр эрхэлдэг бол уг тэтгэмжийг олгохгүй байх үндэслэл болохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

8 дугаар зүйл.Бусад

8.1.Банк, санхүүгийн байгууллага нь энэ хуулийн 5.1-д заасан тэтгэмжийг барьцаалан зээл олгохыг хориглоно.

9 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд дор дурдсан заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.2.12 дахь заалт:

“18.2.12.өрх толгойлсон эх /эцэг/-ийн хүүхэд.”

2/20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт:

“20.2.7.энэ хуулийн 3.1.11-д заасан босго шугамаас доогуур амьжиргаатай өрх толгойлсон эх /эцэг/-ийн хүүхэд.”

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 13.8, 13.1.4, 13.5.5, 13.5.8 дахь заалтыг тус тус хүчингүй болгосугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг